



Барилгын салбар дахь ажил мэргэжлийн замнал

Нийгэм эдийн засгийн нийтлэг ашиг тусын төлөөх
Техникийн болон Мэргэжлийн Боловсрол Сургалт
(ТМБС)-ын өөрчлөлт, шинэчлэлт

Хэвлэлтийг

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Эрхлэн гаргасан:

Бонн болон Эшборн хотуудад
бүртгэлтэй Германы Олон Улсын Хамтын
Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)

“Ур чадварыг хөгжүүлэх” глобал төсөл

Фридрих Эбертийн өргөн чөлөө, 32 + 36,
53113, ХБНГУ, Бонн хот

Монгол Улс дахь

“Ур чадварыг хөгжүүлэх” төсөл

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн
газар, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу 44а, Төрийн өмчийн 11 дүгээр
байр, 4 дүгээр давхар, Монгол Улс,
Улаанбаатар 14191

E: build4skills@giz.de

E: info@giz.de, giz-mongolei@giz.de

E: www.giz.de

Хянасан:

“Ур чадварыг хөгжүүлэх” глобал төсөл,
Бренда Хаас, Планко Консалтинг ХХК,
Яана Шлик

Дизайн/Эх ноорог:

Индиго Коммуникейшн дизайн,
Филин Рат

B4S-Лого:

СС BY-SA 3.0, Совианто-ийн бүтээлд
үндэслэн боловсруулсан Бонн дахь
Медиа компанийн зохиомж

Хэвлэлийн агуулгатай холбогдох
хариуцлагыг GIZ хүлээнэ.

АЖЛЫН ЯВЦ, АХИЦ ДЭВШИЛ: ДЭД БҮТЦИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ ДЭЛХИЙ ДАЯАР ӨСӨН НЭМЭГДЭЖ БАЙНА

Бүтээн байгуулалт бол том бизнес байсаар ирсэн, ирэх он жилүүдэд ч байхаар байна.

Гагцхүү сайн дэд бүтэцтэй байсны хүчинд л дэлхийн эдийн засаг тасралтгүй, хурдацтай өсөж хөгжиж чадна.

Үүнд бид барилгын салбарынханд талархах ёстой. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дэлхий нийтийн хөгжлийн хандлага 2050 онд ямар байх талаар дараах байдлаар төсөөлж байна. Үүнд:

- Дэлхийн хүн ам бараг 10 тэрбум болж өсөх бөгөөд энэхүү өсөлт нь голчлон шинээр үүсэн бий болж буй болон хөгжиж буй орнуудад (ШҮББХБО) гарах бөгөөд Африк тивийн хүн ам л гэхэд хоёр дахин өсч 2.5 тэрбумд хүрнэ.
- Дэлхийн эдийн засгийн өсөлт нь чухам эдгээр ШҮББХБО-дад гарах бөгөөд нэн хурдацтай эдийн засгийн үйл ажиллагаа болон дэлхийн өсөн нэмэгдэж буй дундаж давхаргынхны эрэлт хэрэгцээг хангахын тулд дэд бүтэц үүнтэй хөл нийлүүлэн хөгжих шаардлагатай болно.
- Дэлхийн хүн амын гуравны хоёр нь хот суурин газарт амьдардаг болох тул илүү нарийн, цогц дэд бүтэц шаардлагатай болно.
- Дэд бүтцийн хувьд хүчилтөрөгчийн хий бага ялгаруулдаг технологид болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд дасан зохицох шинэ тогтолцоо бүрдүүлэхэд илүү их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай болно¹.


¹ Humphrey, Chris; Channelling private investment to infrastructure, ODI, April 2018 <https://doi.org/10.3929/ethz-b-000346004>

Эдгээр тоонууд л гэхэд дангаараа барилгын салбарыг ямар чухал ач холбогдолтойг, энэ салбарт урт хугацааны ажлын байр олноороо гарч ирэх болон ингэснээр үүнд хамрагдах нийт хүмүүст нийгэм, эдийн засгийн олон талын ашиг тус ирэхийг бэлхнээ харуулж байна.

Иймд дэд бүтцэд хөрөнгө оруулах төлөвлөгөөнүүд ч бас төдийлөн гайхаад байхаар зүйл биш юм.

Меккэнзи Глобал Институтээс 2016 онд мэдэгдэхдээ 2030 он гэхэд дэлхийн хэмжээнд тээвэр, эрчим хүч, ус болон харилцаа холбоо зэрэг үндсэн салбаруудад дэлхийн ДНБ-ийн 3.8%-тай тэнцэхүйц буюу жилд дунджаар бүхэл бүтэн 3.3 их наяд ам. долларын хөрөнгө оруулалт шаардагдах болно гэсэн байна². Эдгээрийн ихэнх нь Ази тэргүүтэй эдийн засаг нь эрчимтэй хөгжиж буй улс орнуудад оногдох болно.

² Mc Kinsey Global Institute, Bridging Global Infrastructure Gaps, Full Report, June 2016 www.un.org/pga/71/wp-content/uploads/sites/40/2017/06/Bridging-Global-Infrastructure-Gaps-Full-report-June-2016.pdf




ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТ ДЭЛХИЙ ДАХИНД: ӨНӨӨ ҮЕД ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛ ЯАГААД АМИН ЧУХАЛ БОЛООД БАЙНА ВЭ?

Дээр дурьдсан хөрөнгө оруулалтууд хоорондоо уялдаа холбоо бүхий хоёр урьдчилсан нөхцөл хангагдаж байж л хийгдэнэ. Үүнд: барилгын салбар нь бүрэн ажиллагаатай ба орчин үеийн түвшинд хүрч хөгжсөн байх болон чадварлаг ажиллах хүчинтэй байхыг шаардана.

Энд л хэргийн учир байгаа билээ. Тернер ба Таунсенд Интернейшнл байгууллагаас 2019 онд барилгын зах зээлийг судалсан судалгаанд “дэлхийн барилгын зах зээлийн гуравны хоёрт нь ур чадвар дутагдалтай байгаа”-г онцлон тэмдэглэсэн байна³.

Хэдийгээр мэргэшээгүй цагийн ажилчид барилга дээр ажиллахад олдоцтой байдаг боловч, инженерийн сургуулийн оюутнууд болон Мэргэжлийн Боловсрол Сургалтын Байгууллага (МБСБ)-ын дадлагажигчид харин төдийлөн их биш байдаг. Ажлын хүнд ширүүн нөхцөл, (зарим тохиолдолд эрсдэлтэй) орчинтой, барилгын салбарт ажиллах нь “дорд зэрэглэлийн ажил” гэх хандлага түгээмэл байдаг. Мөн мэргэжил эзэмшихсэн, ажиллах дур сонирхолтой эмэгтэй ажилчдыг (<10%) ажилд авахдаа хойрго байдаг зэрэг нь байдлыг улам дордуулдаг.

Хамгийн гол нь дэлхийн нэлээд тооны ТМБС-ын тогтолцоонуудад танхимын хичээлээр мэргэжлийн онолын хичээлийг хуучирсан хөтөлбөрийн дагуу зааж, дадлагын хичээлийг орхигдуулсан хэвээр байна. Ийнхүү бодит ажлын байранд тавигдах шаардлага хангадаггүй, барилгын талбар дээрх гол гол ажлуудын талаар ойлголтгүй төгсөгчдийг бэлтгэн гаргасаар л байна. Засгийн газрууд хувийн хэвшлийнхэнтэй хамтарч байж ТМБС-ын тогтолцоог өөд нь татаж, дээд шатанд гаргах шаардлагатай гэдэг нь ойлгомжтой. Дэлхийн нэлээд улс орнууд хосмог сургалт эсвэл чадамжид суурилсан сургалт (ЧСС) хэрэгжүүлэх зэргээр сургалтыг хөдөлмөр эрхлэлттэй илүү уялдуулах замаар ТМБС-ын тогтолцоогоо шинэчлэхийг оролдож байна. Гэсэн хэдий ч өнөөгийн ТМБС-ын бүтэц тогтолцоо, тэдгээрийн хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд мэдээж асар их цаг хугацаа, хөрөнгө оруулалт шаардагдах нь дамжиггүй.



³ www.turnerandtowsend.com, November 2020

“УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ” ТӨСЛИЙН ЭХЛЭЛ


2018 онд Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ) Азийн хөгжлийн банк (АХБ) – тай хамтран “Ур чадварыг хөгжүүлэх” глобал төслийг Монгол болон Пакистан улсад хэрэгжүүлэхээр эхлүүлсэн билээ.

“Ур чадварыг хөгжүүлэх” төслийн үндсэн санаа нь маш энгийн: МБСБ-ын суралцагчдыг ажлын байрандээр дадлагажуулахад яагаад одоо хэрэгжиж буй дэд бүтцийн төслүүдийг ашиглаж болохгүй гэж? Энд ашиглагдаагүй нооц бэлхнээ байна. Хэрэгжиж буй дэд бүтцийн төслүүдийн бүтээн байгуулалтын талбайд ажлын байран дээрх, үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн сургалтууд зохион байгуулах нь орон нутгийн ажиллах хүчний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлээд зогсохгүй, МБСБ-ын төгсөгчдөд найдвартай ажлын байртай, илүү өндөр цалинтай ажиллах боломж нөхцөл бүрдүүлнэ. Улмаар цаашид удаан хугацаандаа ТМБС-тай хамтарсан байх шаардлагыг яг нийгэм-байгаль орчны стандартын адилаар дэд бүтцийн төслийн тендерт оролцоход тавигдах нэг урьдчилсан нөхцөл, шалгуур болзол болгохыг зорьж байгаа юм.

“Ур чадварыг хөгжүүлэх” төслийг Монголд анх 2019 оны нэгдүгээр сард эхлүүлсэн билээ. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” (УБХГХХХОДХ) – ийн хүрээнд одоо, ирээдүйд хэрэгжих янз бүрийн төслүүд нь ажлын байран дээрх сургалтын “бодит талбар” болж өгнө. “Ур чадварыг хөгжүүлэх” төслөөс барилгын талбарт тавигдах бодит шаардлага хангасан ажлын байран дээрх сургалт зохион байгуулахад техникийн туслалцаа үзүүлдэг.

ОЛОН ТАЛТ ХӨГЖЛИЙН БАНКНУУДАЙ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТҮНШИЛЖ БАЙНА

Хөгжлийн банкнууд дэлхий даяар дэд бүтэц хөгжүүлэхэд арав гаруй жилийн турш санхүүжилт үзүүлсээр ирсэн билээ. Хэдийгээр хэмжээний хувьд багасаж байгаа боловч бүс нутгийн хэмжээний аварга том дэд бүтцийг санхүүжүүлэх хөтөлбөрүүдийг эхлүүлсээр байна. 2016 онд дэд бүтцийн бүтээн байгуулалтад оруулсан санхүүжилт нь Дэлхийн банкны групп болон бүс нутгийн томоохон Олон талт хөгжлийн банк (ОУХБ) – уудын нийт хөрөнгө оруулалтын 34%-тай тэнцэх буюу нийт 39 тэрбум ам. доллар болжээ.



Зураг 1: Дэлхий даяар ОТХБ-аас дэд бүтцийн бүтээн байгуулалтад хийж буй хөрөнгө оруулалтын хэмжээ, хувиар.


Эх сурвалж: ОТХБ-ын 2016 оны тайлан

Ази тивийн хувьд дэд бүтцийн төслүүдийн хамгийн том хөрөнгө оруулагч нь АХБ юм. Ази тивд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг арилгахад чиглэгдсэн дэд бүтцийн бүтээн байгуулалтад оруулах хөрөнгө оруулалтын хэрэгцээг 2030 хүртэл жил бүр 1.7 их наяд ам. доллар шаардагдах тооцоо гарсан байна. Үүний тулд АХБ-аас жилд олгох зээл, буцалтгүй тусламжийн хэмжээгээ 2020 онд 20 тэрбум ам. доллар болгон нэмэгдүүлсэн⁴.

⁴ ADB, Meeting Asia's Infrastructure Needs, 2017 www.adb.org/publications/asia-infrastructure-needs

Африкийн хөгжлийн банк (АФХБ) - ны хувьд дэд бүтэц болон хот суурин хөгжүүлэх төслүүдийн санхүүжилт жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2018 оны нийт санхүүжилтийн 21% буюу 1.9 тэрбум ам.долларыг Африк тив даяар 19 шинэ төслийг санхүүжүүлэхэд зориулсан байна. АФХБ-ны дэд бүтцийн хөрөнгө оруулалтын багцын нийт хэмжээ 15.4 тэрбум ам. доллар байна⁵.

Монгол Улсад засгийн газар нь улс орны хөрөнгө оруулалтын төслүүдийн гол санхүүжүүлэгч бөгөөд 2010 оноос хойш дэд бүтцийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн 42 төсөлд бараг 1 тэрбум ам. долларын санхүүжилт олгохоор баталсан байна. Гэсэн хэдий ч Монгол Улс АХБ, Дэлхийн банк зэрэг гаднын зээл, тусламжаас хамааралтай хэвээр байна. Жишээлбэл, АХБ болон Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА)- аас Монгол Улсын засгийн газарт шууд зээл олгох замаар автозам, онгоцны буудал зэрэг дэд бүтцийн тодорхой төслүүдийг санхүүжүүлсэн.



Зураг 2: Ази тивд дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтын хэрэгцээ, салбараар, 2016-2030 (тэрбум ам. доллар, 2015 оны үнээр)

Эх сурвалж: Монгол дахь АХБ-ы ахлах эдийн засагч Деклан Магийн илтгэл, 2017 он

⁵ AfDB, Infrastructure and Urban Development Department - Annual Report 2018 www.afdb.org/en/documents/document/infrastructure-and-urbandevelopment-department-annual-report-2018-109284

2019 онд АХБ-аас Монголд 3.31 тэрбум долларын 398 төслийг санхүүжүүлсний бараг тал хувь нь дэд бүтцийн төсөл байсан байна. Эдгээр төслийн дотор дээр дурдсан “Ур чадварыг хөгжүүлэх” төслийн хамтрагч УБХГХХХОДХ төсөл бас багтана. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хотын ирээдүйн хөгжлийн гол бүрэлдэхүүн хэсэг болох гэр хорооллын дахин төлөвлөлтийг хотын мастер төлөвлөгөөтэй уялдуулах явдал юм. Хөтөлбөрөөс замын сүлжээг сайжруулах, гол замуудын дагуу дэд бүтцийн сүлжээ байгуулах зэргээр хот төлөвлөлтийг боловсронгуй болгоход гол анхаарлаа хандуулж байна.

“Шинэ торгоны зам” хэмээн олонд танигдсан Хятадын Нэг бүс нэг зам санаачилга нь 2013 онд эхэлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газар Улаанбаатар болон Дарханы хоорондох замын засварыг тэргүүн ээлжид авч үзэж байна. Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон АХБ-аас хамтран санхүүжүүлж буй энэ зам нь Орос-Монгол-Хятадын коридорын нэг хэсэг нь болох ба энэ коридорт хамрагдах улсууд хоорондын төмөр замаа мөн сайжруулах шаардлага бий.

МОНГОЛЫН БАРИЛГЫН САЛБАРЫН ТОЙМ

Монголын барилгын салбар, түүний хөдөлмөрийн зах зээл нь 1990 онд социалист дэглэм нуран унасны дараа үйлдвэрлэл, сургалтын төвлөрсөн тогтолцооноос чөлөөт эдийн засагт харьцангуй хурдан шилжсэн.

Энэ салбарын онцлог нь түүний “бригад”ийн систем юм. Ийм бичил/ жижиг хэмжээтэй албан бус хэсэг бүлгүүд Улаанбаатарт элбэг байх бөгөөд орон нутагт ч бас бий. Эдгээрийн үндсэн бүрэлдэхүүн нь 3-6 хүнтэй. Тэдгээрийн ихэнх нь олон жилийн ажлын туршлагатай ч албан ёсоор ТМБС-д хамрагдаагүй байдаг.

Зарим бригад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байдаг ч, ихэвчлэн хүмүүсийн санал болгосны үндсэн дээр, амаас ам дамжсан зарын дагуу ажил олж хийдэг. Хэдийгээр нийт улс орны барилгын салбарт чухал үүрэг гүйцэтгэдэг боловч ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх, сургалтад хамруулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал болон санхүүгийн менежмент зэргийг үйл ажиллагаандаа төдийлөн тусгадаггүй.

Түүнчлэн улс орны эрс тэс уур амьсгал барилгын салбарт хөдөлмөр эрхлэх сонирхлыг бууруулдаг. Зуны улирал дуусаж, өвөл эхлэхтэй зэрэгцэн ажилчдын хөдөлмөр эрхлэлт 25-50%-ийн хооронд хэлбэлзэж огцом буурдаг. Энэ нь ажилчдын хувьд ажил хөдөлмөр эрхлэлт, амьдралын нөхцөлийг нь баталгаагүй болгохоос гадна ажил олгогчид нь урт хугацаандаа ямар ашигтайг тооцолгүйгээр ажилчдын мэргэжлийн сургалтад хөрөнгө оруулахад хойрго хандахад хүргэдэг байна.

ТМБС-ын салбарт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа үнэндээ хангалтгүй байна. Харин энэ нь одоогийн тогтолцоог сайжруулж, боловсронгуй болгох хамгийн тохиромжтой шийдэл билээ. Учир нь хувийн байгууллагууд өнөөгийн нөхцөлд ажлын байран дээрх сургалтад ямар шаардлага тавигдаж байна, ирээдүйд юу хүлээж байна, түүнд хэрхэн бэлдэх талаар хамгийн сайн зөвлөгөө өгч чадах юм.

МОНГОЛ ДАХЬ ТМБС-ЫН ТОГТОЛЦООНЫ ОРХИГДЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ



Монголын ТМБС -ын тогтолцоо сүүлийн арван жилийн турш олон улсын хандивлагчид, хөгжлийн байгууллагуудын тусалцаатайгаар өөрчлөгдөн шинэчлэгдэж ирлээ. Гэвч өөрчлөлт шинэчлэлт удаан явцтай байна.

Монголд ТМБС-ын багш нарыг сургах сургалтын албан ёсны тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна. Одоогийн байдлаар ТМБС-ын багш нарт суралцагчдад хичээл заахад хамгийн сүүлийн үеийн сургалтын материал, дадлагын хичээлийн ноу-хау, ажлын туршлага дутагдаж байна.



Энэ нь эргээд барилгын салбарыг хурдацтай хөгжиж буй дэд бүтэц, шинэ тутам гарч ирж буй технологид дасан зохицох чадваргүй ажилчидтай хэвээр үлдэхэд хүргэж байна.

2019 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны хүрээлэн (ХНХСХ), Барилга хот байгуулалтын яам (БХБЯ) болон “Ур чадварыг хөгжүүлэх” төсөл хамтран барилгын салбарын хэсэг бүрээр ажиллах хүчний одоогийн байдал болон цаашдын эрэлтийг тодорхойлох судалгаа хийсэн.



Судалгаагаар зөвхөн тухайн жилд л гэхэд нийт **17,700 орон тоо** сул байхад нөгөө талд 3,400 бүртгэлтэй ажилгүй хүмүүс байсан байна. Эдгээрээс зөвхөн ажил хайгчдын 14% нь л ямар нэг байдлаар ТМБС-д хамрагдсан хүмүүс байсан байна. Тэдний тал хувь нь ерөнхий боловсролын сургууль төгсөгчид, 15% нь дээд боловсролтой хүмүүс байжээ.



Энэ салбарт дээд боловсролыг илүүд үзсэн хэвээр л байна. ХНХСХ-ээс 2015–2016 оны төгсөгчдийн дунд хийсэн судалгаагаар их дээд сургууль төгсөгчдийн 90%, ТМБС дүүргэсэн төгсөгчдийн ойролцоогоор 80% нь барилгатай холбоотой ажлын байр олсон байна.

Харин ажил олгогчид чадварлаг ажиллах хүчин ажилд авахад ихэнхдээ нэлээд товогтэй байдгийг дурдсан байна. Энэ нь ихэвчлэн хүмүүс барилга дээр тогтмол ажиллах эсвэл орон нутагт ажиллах сонирхолгүй байдгаас, мэргэжлийн болон суурь ур чадвар дутагдалтайгаас, уур амьсгалын хэцүү нөхцөлд хүнд хөдөлмөр эрхлэхэд бие нь хүрэхгүй байх зэргээс болдог байна.

Үүнээс харахад ажил олгогчид ТМБС төгсөгчдийн чадварт сэтгэл дундуур байдаг ч ТМБС-ын албан ёсны гэрчилгээ нь ажил хайгчдыг хөдөлмөрийн зах зээлд оруулсаар байна.

⁶ Graduate Employment Survey 2017. RILSP RILSP survey results available at: www.rilsp.gov.mn

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТИЙГ МЭРГЭЖЛЭЭР НЬ АВЧ ҮЗВЭЛ:

3%
нь шаварчин
(засал
чимэглэлийн)

3.7%
нь инженер
(барилгын)

10.4%
нь хүнд машин
механизмын
операторч болон
жолооч

6.9%
нь бетон
арматурчин

Эдгээрийн дараа
гагнуурчин,
сантехникч болон
цахилгааны
мэргэжлүүд орж
байна.

8.9%
нь инженер (зам
гүүрний 5.2%,
барилгын 3.7%)

5%
нь мужаан

37.2%
нь барилга, засварын
ажилчид эрэлттэй байна.

Дэлхий нийтээр уур амьсгалын хүлцлийн асуудал моодонд орохын хирээр Монголд хиймэл оюун ухаан, эрчим хүчний хэмнэлт/уур амьсгалын нөлөөллөөс хамгаалах шинэлэг технологи болон хэрэглэгчийн сэтгэл ханамжид илүүтэй анхаарах болж байна. Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд Монголын барилгын салбарын хөдөлмөрийн зах зээл ч мөн адил үйл ажиллагаандаа ногоон практик нэвтрүүлэх шаардлагатай болно.

Гэсэн хэдий ч өнөөгийн ТМБС-ын тогтолцоо нь үүсэн бий болох ногоон ажлын байранд суралцагчиддаа шаардагдах ногоон ур чадвар, чадамж эзэмшүүлэх, бэлтгэн гаргахдаа бэлэн бус хэвээр байна. Иймд хамгийн орчин үеийн шинэлэг технологи нийлүүлэгчид тус улсын өнөөгийн ТМБС-ын бүтэц тогтолцоонд найдахгүй, харин өөрсдөө барилга угсралт, засварын ажлаа гүйцэтгэж байна.

Монгол Улс дахь ногоон ур чадвар шаарддаг ажлын байрууд:



Гинжит техник зэрэг барилгын дэвшилтэт хүнд машин механизм/тээврийн хэрэгсэл болон холбогдох GPS, барилгын лазер, өгөгдлийн утасгүй сүлжээ, интернэт, цахим сүлжээ болон ашиглалтын программ хангамжууд зэрэг холбогдох технологи ашиглах, ажиллуулах



Орчин үеийн халаалт болон халаалт, хөргөлт, агааржуулалт (ХХА) –ын систем суурилуулах болон засвар үйлчилгээ хийх.



Барилгын дулааны тусгаарлалт хийх.



Салхи болон нарны сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх технологийн угсрагч, засварчин

Харин ажиллах хүчний 60% нь 34 – өөс доош настай, тэдгээрийн дотор дийлэнх нь 15-24 насны харьцангуй залуу ажиллах хүчинтэй Монгол Улсад, ялангуяа барилгын салбарын дэд бүтцэд шинээр бий болж байгаа технологийн салбарт ашиглагдаагүй асар их нөөц байна.

ЦААШДЫН ЗАМНАЛ: МОНГОЛЫН ТМБС-ЫГ САЙЖРУУЛАХ

2020 оны байдлаар Монголд төрийн өмчийн 50, хувийн 30 ТМБС-ын байгууллага үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 40,011 оюутан суралцаж байна. Түүнчлэн 712 сургалтын төв, байгууллагууд албан бус мэргэжлийн боловсролын богино хугацааны сургалт зохион байгуулдаг.

ТМБС-ын хөтөлбөрт 14-24 насны залуучуудын 5.8 орчим хувь нь хамрагддаг боловч тэдгээрийн 55% нь л ажлын байранд очиж байна⁷. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) - ны 2020 оны мэдээллээр хамгийн их эрэлттэй байгаа ТМБС-аар олгодог мэргэжлийн 5-аас 2 нь ямар нэг хэмжээгээр барилгын салбартай холбоотой байгаа бөгөөд үүнд шаварчин ба гагнуурчин орж байна.

Оюутны ширээнээс хөдөлмөрийн талбарт шилждэг өнөөгийн практикийг ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд хүртээмжтэй болгох:

2.5-ЖИЛ

Хоёр дахь шатлалын сургалтыг Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ) - д үргэлжлүүлэн суралцаж дүүргээд, мэргэжлийн болон ерөнхий боловсролын хосолсон гэрчилгээ авна; ЭСВЭЛ

1-ЖИЛ

Хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн богино хугацааны сургалтыг Монгол Улсад Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ) эсвэл Политехникийн коллеж дээр дүүргэж, үр чадварын гэрчилгээ авч, хөдөлмөрийн зах зээлд орох ЭСВЭЛ

1.5 – ААС 3-ЖИЛ

Дээрх төгсөгчид болон ерөнхий боловсролын гэрчилгээтэй суралцагчид Политехникийн коллежид 1.5 – аас 3 жил суралцан техникийн боловсролын диплом авч болно. МӨН

Цаашид ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн адилаар их дээд сургуульд элсэн суралцаж болно.

⁷ GIZ, cTVET Mongolia, <https://www.giz.de/en/worldwide/23143.html>

2018 оноос эхлэн дээрх боломжуудаас гадна мэргэжлийн боловсролын албан бус сургалт авах боломжтой болсон. Монголд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) - ны дэргэдэх Мэргэжлийн сургалтын төвүүд дээр хувь хүмүүс “сар хүртэлх хугацаатай богино хугацааны ур чадварын сургалтад” хамрагдах боломжтой болсон. Ажлын байранд шаардагддаг ур чадвар эзэмшүүлэхэд түлхүү анхаардаг эдгээр сургалтын байгууллагууд нь ТМБС-ын албан сургалтын байгууллагын үүргийг гүйцэтгэдэг бөгөөд үйлдвэрлэлд зориулан нэмэлт сургалт (ажлын байран дээрх сургалт) зохион байгуулдаг юм. Албан бус сургалтаар олж авсан чадамжийг МБС-ын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв (МБСҮМАЗТ)-өөр үнэлгээ хийлгэж, гэрчилгээ авах боломжтой бөгөөд ХНХЯ-ны дэргэдэх энэхүү үнэлгээний төвтэй “Ур чадварыг хөгжүүлэх” төсөл хамтран ажилладаг.

Монгол Улсын Засгийн газраас ТМБС-ын тогтолцоог боловсронгуй болгохоор хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөө

Монгол Улсын Засгийн газраас ТМБС-ын чанарыг улам бүр сайжруулах, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байна:

- МБС-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, 2016-2021 нь өнөөгийн ТМБС-ын тогтолцоог бүрэн өөрчлөн шинэчилж, МБС-ыг сэтгэл татсан боловсрол эзэмших, ажил хөдөлмөрийн зохистой хувилбар болгох зорилготой.
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030-д МБС-ын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлж, суралцагчдын тоог өсгөх зорилго дэвшүүлсэн.
- Боловсролын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө (2021–2030-р насан туршийн суралцахуйн хамгийн оновчтой тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэхийг зорьж байна.
- ТМБС-ын бодлого, чанар, мэдээллийн сантай холбогдсон найман хууль эрх зүйн актуудыг УИХ-аар батлан гаргахаар бэлтгэж байна.

Шинэчлэлийн үйл явцын нэг хэсэг бол ХБНГУ-ын Засгийн газраас GIZ-ээр дамжуулан Австралийн гадаад хэрэг, худалдааны яам (DFAT), Солонгосын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА)-тай хамтран 2019 – 2022 онуудад ХНХЯ – тай хамтран хэрэгжүүлж буй “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” төсөл билээ.

Энэхүү төслийн зорилго нь тодорхой сонгосон мэргэжлүүдээр (барилга, механик, цахилгаан гэх мэт) чанарын өндөр түвшинд сургалт зохион байгуулах Чадамжийн төвүүдийг байгуулах болон багш бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох явдал юм.

Мөн Монгол Улсад орчин үеийн шинэ технологи ашигласан шинэлэг арга барил, барилгын ажлын мэргэжлийн чанарыг сайжруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхлээд байна. Геоматрикс болон Ситех зэрэг олон улсын компаниуд өөрсдийн технологийн тогтвортой зах зээлийг хөгжүүлэхийг эрмэлзэхийн зэрэгцээ GIZ зэрэг хөгжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөл бүрийн сургалтын төслүүдийг хэрэгжүүлж байна.

Үүний хажуугаар “Ур чадварыг хөгжүүлэх” төслөөс Монголын барилгын салбар дахь ур чадварын эрэлт, нийлүүлэлтийг харьцуулах зорилгоор цахим платформ байгуулж, боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Энэхүү “Мэргэжлийн ур чадварын орхигдлыг шинжлэх платформ” (МУЧОШП)-ыг МБС-ын ҮМАЗТ хариуцан ажиллуулж байгаа бөгөөд энэ нь боловсон хүчний эрэлт нийлүүлэлтийг, ТМБС-ын нийлүүлэлттэй холбон үзүүлэх боломж олгож байна. Тус платформ нь ийнхүү Монголд хөдөлмөрийн зах зээл дээр шаардагдаж буй ур чадварыг хөгжүүлэх сургалтуудыг төлөвлөн хэрэгжүүлэхэд нь шийдвэр гаргагчдад тус болж байна.

Дэд бүтцийн бүтээн байгуулалтад оруулах дотоодын болон олон улсын томоохон хэмжээний хөрөнгө оруулалт нэмэгдсээр байгаа нь цаашид ч үйл ажиллагаа сайтай барилгын салбар, үүнтэй дүйцэхүйц ТМБС-ын үр дүнтэй тогтолцоо эрэлттэй байсаар байх болно гэсэн үг юм. Иймд хувийн хэвшилтэй хоршсон, орчин үеийн, уян хатан ТМБС-ын системийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх шаардлага ирээдүйд улам бүр нэмэгдэх болно.

Энэ нь яалт ч үгүй нэг л зүйлийг хэлээд байгаа билээ: ТМБС-ийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах цаг нь өнөөдөр, яг одоо болоод байна. Үүнд бүх холбогдох талууд хамтран хүчин чармайлт гаргах шаардлагатай.

Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-аас хэвлэн гаргав.





ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Хэвлэлтийг

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

Германы Олон Улсын Хамтын
Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)

Бонн болон Эшборн
хотуудад бүртгэлтэй

Фридрих Эбертийн өргөн
чөлөө 32 + 36, 53113, ХБНГУ,
Бонн хот
Т +49 228 44 60-0
F +49 228 44 60-17 66

Даг-Хаммарксёлд-Вег 1 - 5
65760 Эшборн, ХБНГУ
Т +49 61 96 79-0
F +49 61 96 79-11 15

E info@giz.de
I www.giz.de